



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/96

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр баг, Шивээт 1 гудамж, 294 тоот хаягт оршин суух Нямбатын Батзаяа (ЧД81013115) нь өөрийн эзэмшлийн 4 дүгээр баг, Шунхлай 81 тоотод байрлах 0000037051 тоот гэрчилгээний дугаартай, 6211000318 нэгж талбарын дугаартай “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор”-ын зориулалттай 3000.0 м² газар, мөн 4 дүгээр баг хаягт байрлах 0000037055 тоот гэрчилгээний дугаартай, 6211004005 нэгж талбарын дугаартай “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор”-ын зориулалттай 2362.0 м² газруудын эзэмших эрхийг сумын 4 дүгээр баг, Шивээт, Гуа 81 тоот хаягт байрлах “Хужирт сүүтэс спа ресорт” ХХК (РД:3569942)-д шилжүүлсэн тул дээрх газруудыг “Хужирт сүүтэс спа ресорт” ХХК (РД:3569942)-д хүсэлтийн дагуу “Рашаан, сувилалын газар”-ын зориулалтаар тус тус гэрээний хугацаа дуусах хүртэл үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн, “Газар эзэмшүүлэх тухай” 58 дугаар, 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Газар эзэмших эрх шинээр олгох тухай” А/157 дугаар захирамжуудыг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМӨНХ

022201101